



“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК

**Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р
баг, өөрийн байр, 206 тоот**

Вэбсайт: www.dmp.mn

**“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар №207**

Тендер шалгаруулалтын дугаар: ДААТҮТӨХК/20260602556

Төсөвт өртөг: 647,000 төгрөг

2026.08.14

ПРИНТЕР ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Зориулалт: “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн гангийн үйлдвэр, Төмөртэй, Төмөр толгойн уурхайн принтерүүдийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор шаардлагатай засвар үйлчилгээ, сэлбэг солих ажлыг шууд худалдан авалтаар гүйцэтгүүлэх.

Гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

- Гүйцэтгэгч нь принтер засварын чиглэлээр мэргэшсэн, шаардлагатай багаж хэрэгсэл, оношилгооны программ болон чадварлаг инженер техникийн ажилтантай байна.
- Засвар, үйлчилгээ болон сэлбэг солих ажлыг үйлдвэрлэгчийн заавар, техникийн шаардлага, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд нийцүүлэн чанартай гүйцэтгэнэ.
- Суурилуулах сэлбэг, эд анги нь шинэ, өмнө ашиглагдаагүй, тухайн төхөөрөмжийн загварт бүрэн нийцсэн байх бөгөөд сэргээн засварласан болон дуураймал эд анги ашиглахгүй.
- Засварын дараа төхөөрөмж бүрийн хэвлэх чанар, цаас таталт, интерфэйсийн холболт, мэдрэгч, алдааны төлөв болон үндсэн ажиллагааг иж бүрэн шалгаж, туршилтын хэвлэл хийнэ.
- Гүйцэтгэсэн ажил болон сольсон сэлбэгт 6 сараас доошгүй хугацааны баталгаа өгнө.

Техникийн үзүүлэлт

1. Epson L3110 принтерийн хэвлэх толгой солих засвар үйлчилгээ

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага / Тайлбар
1	Төхөөрөмжийн загвар	Epson L3110
2	Гүйцэтгэх ажил	Хэвлэх толгойн гэмтлийг мэргэжлийн түвшинд оношилж, гэмтэлтэй хэвлэх толгойг шинэ сэлбэгээр солино.
3	Сэлбэг, нийцлийн шаардлага	Epson L3110 загварт бүрэн нийцсэн, шинэ, өмнө ашиглагдаагүй хэвлэх толгой байна.

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага / Тайлбар
4	Нэмэлт үйлчилгээ	Бэх дамжуулах системийг цэвэрлэж, агааржилтыг арилган, хэвлэх толгойн тохируулга хийнэ.
5	Туршилт, хүлээн авах шалгуур	Nozzle check, өнгөний тохируулга болон туршилтын хэвлэл хийж, бүх өнгө тасалдалгүй, жигд хэвлэж байгааг баталгаажуулна.
6	Баталгаа	Гүйцэтгэсэн ажил болон сольсон сэлбэгт 6 сараас доошгүй хугацааны баталгаа өгнө.

2. Epson L15150 принтерийн maintenance box солих үйлчилгээ

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага / Тайлбар
1	Төхөөрөмжийн загвар	Epson L15150
2	Гүйцэтгэх ажил	Maintenance box болон хаягдал бэхний системийн төлөв, алдааны кодыг иж бүрэн оношилно.
3	Сэлбэг, нийцлийн шаардлага	Хаягдал бэхний сав, шингээгч дэвсгэрийн багтаамж дууссан бол захиалагчтай зөвшилцөн шаардлагатай үйлчилгээ, солилтыг хийнэ.
4	Нэмэлт үйлчилгээ	Үйлдвэрлэгчийн зориулалтын программ ашиглан maintenance counter-ийг reset хийж, системийн алдааг арилгана.
5	Туршилт, хүлээн авах шалгуур	Бэх алдалтгүй, алдааны мэдээлэлгүй асах, өөрийгөө цэвэрлэх болон хэвлэх ажиллагаа хэвийн болохыг туршина.
6	Баталгаа	Гүйцэтгэсэн ажил болон сольсон сэлбэгт 6 сараас доошгүй хугацааны баталгаа өгнө.

3. Epson L15158 принтерийн maintenance box солих үйлчилгээ

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага / Тайлбар
1	Төхөөрөмжийн загвар	Epson L15158
2	Гүйцэтгэх ажил	Maintenance box болон хаягдал бэхний системийн төлөв, алдааны кодыг иж бүрэн оношилно.
3	Сэлбэг, нийцлийн шаардлага	Хаягдал бэхний сав, шингээгч дэвсгэрийн багтаамж дууссан бол захиалагчтай зөвшилцөн шаардлагатай үйлчилгээ, солилтыг хийнэ.
4	Нэмэлт үйлчилгээ	Үйлдвэрлэгчийн зориулалтын программ ашиглан maintenance counter-ийг reset хийж, системийн алдааг арилгана.
5	Туршилт, хүлээн авах шалгуур	Төхөөрөмж алдаагүй асах, өөрийгөө цэвэрлэх, цаас татах болон хэвлэх горим хэвийн ажиллахыг туршина.

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага / Тайлбар
6	Баталгаа	Гүйцэтгэсэн ажил болон сольсон сэлбэгт 6 сараас доошгүй хугацааны баталгаа өгнө.

4. HP LaserJet M1132 MFP принтерийн USB интерфейсийн плат солих

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага / Тайлбар
1	Төхөөрөмжийн загвар	HP LaserJet M1132 MFP
2	Гүйцэтгэх ажил	USB холболтын гэмтлийг оношилж, гэмтэлтэй интерфейсийн плат буюу холболтын самбарыг шинэ сэлбэгээр солино.
3	Сэлбэг, нийцлийн шаардлага	HP LaserJet M1132 MFP загварт цахилгаан болон механик холболтоор бүрэн нийцсэн шинэ USB интерфейсийн плат байна.
4	Нэмэлт үйлчилгээ	Холбогдох кабель, залгуур, контакт болон тэжээлийн хүчдэлийг шалгаж, угсралтыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу гүйцэтгэнэ.
5	Туршилт, хүлээн авах шалгуур	Компьютерт драйверын түвшинд зөв танигдах, USB өгөгдөл дамжуулах, хэвлэх болон сканнердах ажиллагааг туршина.
6	Баталгаа	Гүйцэтгэсэн ажил болон сольсон сэлбэгт 6 сараас доошгүй хугацааны баталгаа өгнө.

5. Epson L15158 принтерийн хэвлэх толгойн мэдрэгч, картрижийн иж бүрдэл солих

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага / Тайлбар
1	Төхөөрөмжийн загвар	Epson L15158
2	Гүйцэтгэх ажил	Хэвлэх толгойн мэдрэгч, бэх болон картриж таних системийг иж бүрэн оношилж, гэмтэлтэй эд ангийг солино.
3	Сэлбэг, нийцлийн шаардлага	Тухайн загварт бүрэн нийцсэн шинэ хэвлэх толгойн мэдрэгч болон хорны картрижийн иж бүрдэл байна.
4	Нэмэлт үйлчилгээ	Контакт, кабель, бэх дамжуулах хоолой, холболтуудыг шалгаж цэвэрлэн, шаардлагатай тохируулгыг хийнэ.
5	Туршилт, хүлээн авах шалгуур	Картриж, бэхний түвшнийг алдаагүй таних, бэх дамжуулалт болон өнгөт хэвлэлийн чанар хэвийн болохыг туршина.
6	Баталгаа	Гүйцэтгэсэн ажил болон сольсон сэлбэгт 6 сараас доошгүй хугацааны баталгаа өгнө.

6. Epson L1800 принтерийн картрижийн мэдрэгч, индикатор засварлах

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага / Тайлбар
1	Төхөөрөмжийн загвар	Epson L1800
2	Гүйцэтгэх ажил	Картрижийн мэдрэгч болон индикаторын цахилгаан хэлхээг оношилж, шатсан болон гэмтэлтэй эд ангийг солино.
3	Сэлбэг, нийцлийн шаардлага	Epson L1800 загварт бүрэн нийцэх шинэ мэдрэгч, индикатор эсхүл шаардлагатай цахилгаан эд ангийг ашиглана.
4	Нэмэлт үйлчилгээ	Мэдрэгчийн контакт, кабель, холболтын плат болон тэжээлийн хэлхээг шалгаж, угсралт тохируулгыг хийнэ.
5	Туршилт, хүлээн авах шалгуур	Бүх өнгийн картрижийг зөв таних, индикаторын заалт зөв ажиллах болон өнгөт хэвлэлийн ажиллагааг туршина.
6	Баталгаа	Гүйцэтгэсэн ажил болон сольсон сэлбэгт 6 сараас доошгүй хугацааны баталгаа өгнө.

7. HP LaserJet M1319f MFP принтерийн үндсэн араа солих

№	Үндсэн үзүүлэлт	Үндсэн шаардлага / Тайлбар
1	Төхөөрөмжийн загвар	HP LaserJet M1319f MFP
2	Гүйцэтгэх ажил	Цаас татах, дамжуулах механизмын гэмтлийг оношилж, хугарсан үндсэн арааг шинэ араагаар солино.
3	Сэлбэг, нийцлийн шаардлага	HP LaserJet M1319f MFP загварт хэмжээ, шүдний тоо, голын суултаар бүрэн нийцсэн шинэ үндсэн араа байна.
4	Нэмэлт үйлчилгээ	Механизмын гол, втулк, холбогдох араануудын элэгдэл, тэнхлэгжилт болон тосолгоог шалгаж тохируулна.
5	Туршилт, хүлээн авах шалгуур	Янз бүрийн төрлийн цаасаар олон удаагийн туршилт хийж, цаас гацахгүй татах, дамжуулах, хэвлэх ажиллагааг баталгаажуулна.
6	Баталгаа	Гүйцэтгэсэн ажил болон сольсон сэлбэгт 6 сараас доошгүй хугацааны баталгаа өгнө.

Хүлээлгэн өгөх ба шалгах нөхцөл

- Гүйцэтгэгч нь төхөөрөмж тус бүрийг захиалагчийн төлөөлөлтэй хамт туршиж, хэвлэх чанар болон үндсэн ажиллагаа техникийн шаардлага хангасны дараа акт үйлдэн хүлээлгэн өгнө.
- Сольсон сэлбэгийн нэр, загвар, тоо хэмжээ, гүйцэтгэсэн ажил болон баталгааны хугацааг тусгасан засвар үйлчилгээний тайланг хүлээлгэн өгнө.
- Засварын явцад илэрсэн нэмэлт гэмтэл, төлөвлөгдөөгүй сэлбэг солих шаардлагыг захиалагчид урьдчилан мэдэгдэж, бичгээр зөвшөөрөл авсны дараа гүйцэтгэнэ.

- Хуучин сэлбэг, гэмтэлтэй эд анги болон засварын явцад гарсан хог хаягдлыг захиалагчийн шийдвэрийн дагуу хүлээлгэн өгч, ажлын талбайг цэвэрлэнэ.
- Гэрээ байгуулснаас хойш ажлыг 20 хоногийн дотор бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгнө.

Засвар үйлчилгээ гүйцэтгэх хуваарь

№	Засвар үйлчилгээний нэр	Тоо	Гүйцэтгэх хугацаа
1	Epson L3110 принтерийн хэвлэх толгой солих засвар үйлчилгээ	1	5 хоног
2	Epson L15150 принтерийн maintenance box солих үйлчилгээ	1	5 хоног
3	Epson L15158 принтерийн maintenance box солих үйлчилгээ	1	5 хоног
4	HP LaserJet M1132 MFP принтерийн USB интерфейсийн плат солих	1	5 хоног
5	Epson L15158 принтерийн хэвлэх толгойн мэдрэгч, картрижийн иж бүрдэл солих	1	5 хоног
6	Epson L1800 принтерийн картрижийн мэдрэгч, индикатор засварлах	1	5 хоног
7	HP LaserJet M1319f MFP принтерийн үндсэн араа солих	1	5 хоног

Жич:

- Урьдчилгаа төлбөр олгохгүй
- Төлбөрийг бараа нийлүүлж, бараа хүлээн авалтын акт үйлдсэний дараа нэхэмжлэхийг үндэслэн 30 хоногийн дотор төлнө.
- Оролцогч нь баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.

Бүрдүүлж ирүүлэх материал:

- Албан бичиг /Үнийн санал, бараа нийлүүлэх хугацаа, баталгаат хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/
- Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ
- Нийлүүлэх барааны үзүүлэлт, танилцуулга, бусад нотлох баримт
- Холбогдох мэйл хаяг, утасны дугаар

Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:

2026 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл

Шууд худалдан авалттай холбоотой тодруулга

болон үнийн санал хүлээн авах мэйл хаяг:

procurement2@dmp.mn

Утас/факс: 7509-0044